

ЭРДЭНЭЗУУ ХИЙДИЙН ИХ ЦОРЖ, ШИРЭЭТ ЛАМ ЛУВСАНДАГВАДАРЖАА /1732-1803/

С.Ичинноров

Нийгмийн ухааны дээд сургууль.

Өгүүллийн товч утга: Эл өгүүлэлд Эрдэнэзуу хийдийн их цорж, ширээт лам Лувсандагвадаржаагийн намтар, үйл ажиллагаа, номын буяныг хураангуйлан авч үзсэн болой.

Түлхүүр үг: Эрдэнэзуу, мэгзэм, тарина, цорж, Автай сайн хан, цогчин дугана, авшиг, соёмбо, агримба, тахилга, сүмбум.

Лувсандагвадаржаа ламтан нь 12 дугаар жаран хотол баясгалант хэмээх шороон барс жил /1734 онд/ Орхон мөрний ойролцоох Хангайн нурууны Бага Арцат (одоогийн Хар хорин сумын нутаг) газар эцэг Салдүв, эх Дайрийжав нарын хүү болон мэндэлжээ. 3 настайд нь Эрдэнэзуу хийдийн Ганжирваа цорж Лувсанжанцан ламтнаас Лувсандагвадаржаа хэмээх тойн санваарын нэр хайрлаж, гэлэн сахил хүртжээ. Лувсандагвадаржаа ламтны сахилын нэр нь Хасбазар, олонд алдаршсан нэр нь Балганшадавдорж гэдэг. Түүний бүтээл нь гол төлөв Лувсандагвадаржаа, Балганшадавдорж нэрээр гарч байжээ. Тэрбээр 5 настайгаасаа мэгзэм, тарина зэрэг ном, уншлагыг чөлөөтэй унших болж, их номын хүн болж өсөх билэг авъяас нь тодорчээ. Лувсандагвадаржаа нь нь тухайн үеийн нэрт эрдэмтэн мэргэдийн судар таринаас суралцаж, 1743 онд II Богд Лувсандамбийдогмийг Эрдэнэзууд залрах үед шавь орж Цэвээн хүртэх, Чин сүжигт Номун хан хутагт Норовшийравт шавь орж, "Дүнтэв ринжунгийн жанан" хүртжээ. 1757 онд Их хүрээнд ирж номын их мэргэдтэй уулзаж, эрдмийн холбоо тогтоожээ. 1760 онд Лувсандагвадаржаад номч цорж цол хүртээж Эрдэнэзуу хийдийн VII ширээт ламаар өргөмжилжээ. Лувсандагвадаржаа цорж Гомбын нинчин хэмээх их бясалгалыг үйлджээ. 1763 онд III Богд Лувсандамбийнямд мандал өргөж, тухайн үеийн Монголын нэрт эрдэмтэд ламын гэгээн Лувсанванчинбалбар, Зая Бандида Лувсаннамжилгэлэгмяндаг, Чин сүжигт Номун хан Норовшийрав нартай багш шавь, номын барилдлага тогтоожээ. Цорж Ламтан Лувсандагвадаржаа Эрдэнэзуу хийдийг өргөтгөн байгуулах, засч шинэчлэхэд их анхаарч, үлэмжийг хийж бүтээжээ. Түүний нэг нь Эрдэнэзуу хийдийн их цогчин Хурлын дуганыг барьж бүтээх санаачлагыг анх гаргаж, тухайн үеийн өвгөн Түшээт хан Цэрэндоржид айлтгасанд хаантнаас Та бидний хүчин хүрэхгүй буй заа хэмээх хариу өгсөн ажээ. Гэвч Цорж ламтны зориг мохсонгүй ихэс дээдэс, сүсэгтэн олон хүнтэй уулзаж учран, Цэцэн хан аймгийн олон хошуудаар, Утай Гүмбэнээр аялан явахад өглөгийн эзэд олноор тодорч алт, мөнгө, эд, мал тэргүүнтэн хуран цуглаж, их цогчин дуганыг Эрдэнэзуу хийдийн Хэрмийн дотор Автай сайн ханы өргөөний буйрын хойд талд барих ажил эхлэн, хэдэн жил үргэлжлэн, уран дархчууд олноор ирж оролцон, буян үйлдсэний үрээр Эрдэнэзуу хийдийн их цогчин Хурлын дуганыг 1770 оны цагаан барс жил барьж дуусгажээ. 1780 онд Банчин Богд Лувсанбалдан-Ишийг Бээжинд морилоход Лувсандагвадаржаа цорж очиж бараалхан, цогчин дуганд нэр хайрлахыг айлтгасанд Дамбаравжанлин нэр өгчээ. Их цогчин дуганыг энэ зууны гуч, дөчөөд оны их хэлмэгдлийн жилүүдэд эвдэн устгасан бөгөөд буйр туйр нь өдгөө тодорхой байдаг. Цогчин дуганыг байгуулсны дараа жас сан байгуулж, VII Цорж ламтан өөрийн хөрөнгөнөөс 2000 лан мөнгө, эд зүйл өргөсөн зэрэг өглөгийн хандиваар жас сангийн хөрөнгө, мал сүрэг хуран цуглаж жас, сан байгуулж, олон түмний тусын тулд Ламирим хурлын өдөр бүрийн тахил, манж, цавын зардлыг эрхлүүлжээ. Ийнхүү Эрдэнэзуу хийдийн их цогчин дуганыг барьж бүтээх ажлыг Ширээт лам их цорж Лувсандагвадаржаа ламтан, өөрийн шавь нарын хамт их хүчин зүтгэл гаргасан хэмээн Эрдэнэзуугийн уг эхэд тэмдэглэжээ.

Лувсандагвадаржаа ламтан Жанжаахутагт Ролбийдоржид Эрдэнэзууд Гомбогүрийн уншлага ёсыг дэглэх тухай хүссэн захиа илгээсэнд Ролбийдоржоос өөрөө юм уу, өөр нэг сайн хүнийг Түвдийн Сажа руу явуулж, авахуулах хэрэгтэй гэж зөвлөсөн байна. Түүнээс хойш Сарайдорж Номун хан Жамбалдорж зэрэг хүмүүстэй цогчин гэсгүй Лувсанчойдүвийг Түвд рүү явуулж Сажийн хийдээс Сажа лам Агваангунгаалодойсанжаадамбийжанцанд бараалхан Гомбогүрийн 12 бурхан нөхөр сэлтийн авшгийг хүртсэн байна. Сажа ламаас Эрдэнэзууд олон нандин шүтээн болон Сажийн таван дээдсийн бүрэн зохиол, Чойжүн зэрэг номуудыг бэлэглэжээ. Лувсанчойдүв гэсгүй Эрдэнэзууд ирээд Гомбогүрийн бүтээлийг үйлдэж, Сажийн ёсны Гомбогүрийн дэг ёсыг шинэчлэн дэглэсэн байна. 1780 онд Банчин Богд Лувсанбалданишийг Бээжинд морилоход нь цорж ламтан очиж уулзан цайш хамт явж, Банчин Богдтой Долнуурт очиж Жанжаа хутагт Ролбийдоржид бараалхан шавь оржээ. Цорж ламтан 45 настайдаа олон зүйлийн Гүр дууллыг зохиосон байна. 1781 онд IV Богд Лувсантүвдэнванчигжигмэдхамцад мандал өргөв. Их цорж Лувсандагвадаржаа ламтан бол их Занабазар богд Гэгээнтний бүтээсэн соёмбо үсэг бичгийг их судалсан эрдэмтэн юм. Тэрбээр 1789 онд Соёмбо үсгийн бар сийлүүлж, 1796 онд "Соёмбо зояади" хэмээх Монгол үсгийн түүхийг товчлон хурааж үзүүлсэн огторгуйн чандмань хэмээгдэх оршвой" хэмээх соёмбо үсгийн тайлбар номоо Өндөр гэгээн Занабазарын бүтээлийн сүм эвамангачил буюу Төвхөнд бүтээн туурвижээ. Лувсандагвадаржаа ламтан Бээжинд морилон очиж, Жанжаа хутагт Ролбийдоржид бараалхаж өөрийн зохиосон соёмбын тайлбар номоо айлтгасанд хутагт ихэд магтаж Да цамжүрийг үзэж, судлахыг зөвлөсөн байна.

Лувсандаржаа ламтан соёмбын тайлбар бүтээлдээ: Өндөр гэгээнтний гучаад жил болгоон бясалгаж бүтээсэн Соёмбын гүн гүнзгий агуулгыг гүйцэд гаргахад хүчин мөхөсдөв хэмээн бичжээ. Соёмбо бичиг нь тухайн цагийн Монгол утга зохиолын хэл авиалбарын тогтолцоог дорно дахины хэл шинжлэлийн ухааны арга билгийн зарчимд үндэслэн улам боловсронгуй болгон, алс ирээдүйг угтан харсан шинжлэх ухааны бүтээл ажээ. Лувсандагвадаржаа цорж Эрдэнэзууд Дашнимаалин гэдэг сүмд Маналын лойлин бүтээж, Гү-аа Дамдин зэрэг бурхадыг гол шүтээнээр залжээ. 40 наснаасаа эхлэн Төвхөн хийдэд очиж нямба бясалгал хийсэн байна. Халх, Өөлдийн дайн самууны үед бурхан шүтээн нь эзгүйрсэн болон Цорж ламтан Өндөр Гэгээнээс хойш Төвхөн хийдийг дахин сэргээж, бурхан шүтээнийг нь ил гаргаж залсан байна. Лувсандагвадаржаа лам Төвхөнд бясалгал бүтээл хийн олон зохиол туурвисны дотор 1786 оны гал морин жил Төвхөний байгалын үзэсгэлэнг магтан дуулсан онц сонирхолтой хоёр Гүр дууллыг зохиожээ. Мөн "Өндөр хангай" зэрэг олон уртын дууны үг, аяыг зохиосон гэдэг.

Хүрээнд байсан агримба Сэнгэравданг Эрдэнэзууд залж, Эрдэнэзуугийн Их цамыг дэглүүлсэн юм. Сэнгэравдан "Цамын номлол Сэд бүтээн хүслийг хангагч" гэдэг цамын тухай зохиолоо туурвижээ. Эрдэнэзуу хийдэд номч цорж Лувсандагвадаржаа ламрим дацан байгуулсан байна. Номч цорж Лувсандагвадаржаа Жарантайн халуун рашаан, Тэмээтийн рашаанд дахин дахин саатахын хажуугаар их Номгон, Их Арцат, Бургалтай зэрэг газарт саатаж ном зохиолоо туурвиж байжээ. Халх Сэцэн хан аймгийн амбан гүр Баатар, мэргэн дайчин Гомбожав, Бэрэвүн номун хан Цэдэндорж нарын урилгаар Хөвчийн Жонон вангийн хошууны Балдан Бэрэвүн хийдэд очиж, тэнд ламрим дацан Пунцагтэгчинлинг байгуулсан байна. Мөн лам нарт соёмбо үсгийг зааж сургаж, Мөнх Өлзийт уулын тахилгыг зохиожээ. Манзушири ламтны хийд Дашчойхорлинд саатан морилж байв. Засагт ханы Хотгойдын засаг хошуу Дөрвөдийн арван хошууны хийд Ганданшадивлин, Илжгин хошууны дацан Дашдаржаалин зэрэг газар оронд залагдаж байв. Мөн Урианхай ширхтэний нутагт уригдан морилжээ. Монголын газар орноор явж байх зуураа Хөвсгөл

далайн тахилга, Авзага хангайн тахилга зэрэг номуудыг зохиосон байна. Намтрын дотор уулзаж бараалхаж байсан олон ноёд хатдын дотроос Очирай Түшээт хан Цэдэндоржийн хатан Ж.Бүнгэйн Цогт дар Осоржид гэдэг хүн олон тооны ном зохиол айлтгаж зохиолгосон байна. Сайшаалт Ерөөлтийн 8-р дугаар он буюу 1803 онд 70 настайдаа таалал төгссөнийг Эрдэнэзуугийн баруухан хойно Эрдэнэтив толгойн өвөрт бунхалжээ. Гэтэл тэр бурханд анхнаасаа ямар нэг бичиг тэмдэг байгаагүй тул өдгөө учир нь үл мэдэгдэх болсныг зохиогч С.Ичинноров би хэдэн жил нягтлан судалж, Эрдэнэзуу хийдийн ширээт лам VII их цорж Лувсандагвадаржаа ламтны бунхан мөн болохыг судлан тогтоож, уг бунхныг засч сэлбэхийг Эрдэнэзуу хийдийн хамба ламтан Б.Намхайжамцад айлтгасныг ламтан хүлээн авч уг бунхныг Эрдэнэзуугаас 700 000 төгрөг гаргаж засуулж буян үйлдсэнийг тэмдэглэж байна. Номч мэргэн цорж хувилгаан Лувсандагвадаржаа нь түвд хэлээр зохиолоо бичиж байсан олон эрдэмтдийн нэг юм. Түвд хэлээр зохиолоо бичиж байсан эрдэмтдийн дотроос хамгийн олон зохиол 30 сүмбүм буюу 30 боть зохиол туурвиснаар Лувсандагвадаржаа цорж тэргүүлж байна. Самгарьд түвд хэлийг төгс эзэмшсэн их цоржийн бүтээл өдгөө Гандантэгчилэн хийдийн номын санд байдаг ажээ. Лувсандагвадаржаа цорж ламтны бүтээлийн тухай номч мэргэн гавж С.Гомбожав, академич Б.Ринчин, доктор Ц.Шагдарсүрэн, Ш.Сонинбаяр нарын эрдэмтэд бүтээлдээ хөндөж тавьсан байх бөгөөд энэ хэр тусгайлан судалсан нь үгүй байна. Түвд хэлээр бичсэн энэ эрдэмтний бүтээл нь цаашид зайлшгүй судлах шаардлагатай сэдвийн нэг мөн билээ. Лувсандагвадаржаагийн бүтээл нь гүн ухаан, дуун ухаан, түүх, аж төрөх ухаан, ёс зүйн тухай зэрэг их өргөн хүрээтэй ажээ.

Abstract:

This article about the biography of “ikh tsorj[king of law], shiret lam[roughly equal to abbot]” Luvsandagvadarjaa(1732-1803). The emeritus scholar in his times contributes many things to science.

Ном зүй

1. Монгол улсын үндэсний төв архивт буй "Түшээт хааны хошууны нутаг дахь номын сургууль, орон хийд, хурал номын газар" хэмээх бичмэл
2. Х.Нямбуу, С.Ичинноров, Д.Дашбалдан Өндөр Гэгээн Занабазар. Сөүл 1995 он
3. Л.Хүрэлбаатар: Анхдугаар Богд. УБ. 2001 он
4. С.Ичинноров. Ч.Банзрагч. Эрдэнэзуу хийд ба Түшээт хааны хошуу. УБ., 1999 он